


**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМЫН МАН-ЫН ХОРООНЫ ОРОН
НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, “СУМЫН ШИНЭ ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ-ХҮЧЭЭ НЭГТГЭЭ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2020-2024/**

2020 ОН



Бигэр сумын МАН-ын хорооны
2020 оны 06 сарын 23-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМЫН МАН-ЫН ХОРООНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, “СУМЫН ШИНЭ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ-ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2020-2024/**

УРИА: Хөгжлийн төлөө,
Тогтвортой сонголт.

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ - НИЙГМИЙН ДЭВШИЛ


1. Эрүүл мэндийн бодлого
2. Биеийн тамир, спортын бодлого
3. Боловсрол, соёлын бодлого
4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого
5. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийг дэмжих бодлого

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЭЦ - АЖЛЫН БАЙР, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

1. Мал аж ахуйг эрчимжүүлэх
2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх
3. Сумын дэд бүтцийг сайжруулах
4. Нэгдсэн халаалт, цэвэрлэх байгууламж байгуулах
5. Зам харилцааг сайжруулах
6. Бизнес эрхлэлтийг дэмжих
7. Төсөл, зээлийн таатай орчныг бий болгох
8. Ажлын байрыг нэмэгдүүлэх

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Онгон байгалиа хамгаалах
2. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх
3. Бичил уурхай иргэдийн оролцоо
4. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлнэ
5. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж



ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ИРГЭН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ

1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ.
2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ
3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ – НИЙГМИЙН ДЭВШИЛ

Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж, хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдарлын чанарыг дээшлүүлнэ.

1.1. Эрүүл мэндийн бодлого

1.1.1. Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

1.1.2. Гадаад дотоодын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан эрүүл мэндийн болон биеийн тамирын мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулна.


1.1.3. “Эрүүл хүүхэд – Бигэрийн ирээдүй” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

1.1.4. Эх, хүүхдийн эндэгдлийг гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

1.1.5. Эмч, эмнэлгийн ажиллагсдын нийгмийн баталгааг хангаж, орон нутгийн нөөц бололцоогоор нэн чухал шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэж хангана.

1.1.6. Эрүүл мэндийн явуулын үзлэг, оношилгоог холбогдох дээд байгууллагатай хамтран, сум болон багт жил бүрт зохион байгуулна.

1.1.7. Ахмадуудыг эмнэлгийн үзлэг оношилгоонд хамруулж, эмчилгээ сувилгаанд тогтмол хамруулна



1.2. Биеийн тамир, спортын бодлого.

1.2.1. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгон хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлж, чийрэгжүүлэх танхимыг сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлжнэ.

1.2.2. Сумын тамирчдыг улс бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцох нөхцлөөр хангаж дэмжиж ажиллана.

1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох нөхцөлөөр хангана.

1.2.4. Шатрын спортыг хөгжүүлэх зорилгоор Аймгийн чанартай шатрын тэмцээнийг сумдаа зохион байгуулна.

1.2.5. Нийтийн биеийн тамир спорт холбоодын зөвлөгөөнийг зохион байгуулж сумдаа тусгай хөтөлбөр гарган ажиллана.


1.3. Боловсрол, соёлын хөгжлийг дэмжих бодлого

1.3.1. Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, мэргэшилтэй багш, соёлын ажилтнуудыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.

1.3.2. Боловсрол, соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжиж, хувиараа нэмэлт болон гүнзгийрүүлэн судлах сургалтын орчинг бүрдүүлнэ.

1.3.3. Урлагийн гоц авъяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулан авъяасыг нь хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.3.4. Сумын соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх олны хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататгаж, дэлхийн соёлын өвд бүртгүүлэх, томоохон хэмжээний зан заншил соёл, өв тээгчдийг илрүүлэн урамшуулах баталгаажуулах ажлыг зохион байгуулна.



1.3.5. Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

1.4.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг, эмзэг бүлгийн иргэдэд хүртээмжтэй болгож, нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд сумын хүн амын хамралтыг нэмэгдүүлнэ.

1.4.2. Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг багасган, өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

1.4.3. Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.

1.4.4. Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.4.5 Малчдын нийгмийн хамгааллын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар шинэ санаачилга гаргаж, залуу малчдыг бүх талаар дэмжинэ.


ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЭЦ - АЖЛЫН БАЙР, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн үр ашгийг нь нэмэгдүүлж, ажлын байр бий болгон ард иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.1. Мал аж ахуйг эрчимжүүлэх

2.1.1. Мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг тогтсон хугацаанд явуулж, боом шүлхий зэрэг олон улсын худалдааны хорио цээр, өвчнөөс эрүүл бүсийн статусаа хадгалж галзуу, бруцеллоз зэрэг халдварт өвчний гаралтыг бууруулна.

2.1.2. Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримталж, байгууллага аж ахуйн нэгжийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, айл өрх, иргэд худалдаа



эрхлэгчдийн орлогыг өсгөхөд шаардагдах орон нутгийн шийдвэрүүдийг богино хугацаанд гаргаж ажиллана.

2.1.3. Малжуулах аяныг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай малчин өрхийг малжуулах.

2.1.4 Орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан малын таваарлаг байлдыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

2.1.5. Сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.6. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор худаг, хөв зэрэг уст цэгийн тоог нэмэгдүүлэх

2.1.7. Бэлчээрийг улирлын хуваарийн дагуу ашиглах, өнжөөж сэргээх, хашиж хамгаалах зэрэг арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, хортон мэрэгчидтэй тэмцэх ашигтай аргыг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлнэ.

2.1.8 Ариутгал халдваргүйжүүлэлтийн тусгай зориулалтын машин техниктэй болох /Дүк машин/

2.1.9 Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах


2.2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх

2.2.1 Сумын хэмжээнд тогтоогдсон усалгаатай тариалан эрхлэх боломжтой газруудыг эргэлтэнд оруулах зорилт тавьж, төмс хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.2.2. Усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлж түүнд түшиглэсэн тэжээлийн бага оврын үйлдвэр байгуулна.

2.2.3. Жимс жимсгэнэ, чацарганы тарилалтыг нэг дахин нэмэгдүүлнэ..

2.2.4. Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, ялангуяа өвлийн дулаалгатай хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.



2.3. Бизнес эрхлэлтийг дэмжих

2.3.1 Сум орон нутагт бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлж ажиллана.

2.3.2. Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор бичил уул уурхай, алт олборлогчдын бүлэг, нөхөрлөлийн эрх ашгийг хамгаалж, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.3.3. Сумд брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхийг дэмжин, стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлж, борлуулалтын сүлжээ бий болгоно.

2.3.4. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулан, ажлын үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.5. Гарааны бизнес эрхлэгчдэд аж ахуй эрхлэх сургалтуудыг зохион байгуулж, тэднийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, техник технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах явцад нь зөвлөгөө өгөх ажиллагааг зохион байгуулна.

2.3.6. Хувийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн бодит салбарт оруулах нөхцөл боломжийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.4 СУМЫН ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ

Хүн амын аятай амьдрах орныг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэн, дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ.


2.4.1 Сумын дэд бүтцийг сайжруулах зорилгоор салбар бүрт төсөв, болон төсөл хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана.

2.4.2 Төвлөрсөн дулаан хангамж цэвэр усны шугам сүлжээнд холбох

2.4.3 Бохир соруулдаг машинтай болох

2.4.4 Сумд тохирсон бага оврын цэвэрлэх байгууламж барих

2.4.5 Бигэр сумын аймгийн төвтэй засмал замаар холбох



2.4.6 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баяр наадмын талбайг шинээр барих

2.4.7 Төвийн хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн смарт худаг барих

2.4.8 Сумын төвийн цахилгаан хангамжийн под станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх

2.5. Төсөл зээлийн таатай орчинг бий болгох

2.5.1. Төсөл хөтөлбөрийн нэгдсэн бодлого боловсруулж , төсөл хөтөлбөрт өрх бүрийг жигд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.5.2. Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган олон улсын болон үндэсний хөрөнгө оруулалтын сүлжээг татах, хэрэгжүүлэхэд улс төр болон нийгмийн таатай нөхцөлийг бий болгоно.

2.5.3. Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.


2.6. Ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.6.1.Орон нутагт боловсон хүчний бодлого боловсруулж шинээр гарсан ажлын байранд сонгон шалгаруулалтаар мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулах бодлого барина.

2.6.2.Орон нутагт байгаа байгалийн баялагийг судлах, нээх, илрүүлэх, хайгуул судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар зохих зөвшөөрлийн үндсэн дээр хуулийн хугацаанд багтаан хийлгэх шаардлага тавьж орон нутаг, төдийгүй улсын хэмжээний стратегийн ач холбогдол бүхий томоохон ордыг нээх, ашиглах асуудлыг дэмжиж түүнд ажиллах боловсон хүчнийг орон нутгаас хангах бодлого барин ажиллана.

2.6.3. Ажилгүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэг, нөхөрлөл, хоршоололд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоож, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.1. Онгон байгалиа хамгаалах

3.1.1 Өөшд мод үржүүлгийн талбайг нэмэх замаар таримал ойн талбайг одоогийн түвшингээс нэмэгдүүлнэ.

3.1.2. Айл өрх бүр хашаандаа жимсний мод тарих, хүлэмж байгуулан хүнсний нарийн ногооны хэрэгцээгээ хангах ажлыг дэмжиж ажиллана.

3.1.3 Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллана.

3.1.4. Ховордож байгаа амьтан, ургамлыг хамгаалах ажлыг хийнэ.

3.1.5. “Ногоон- Алтай” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэн байгуулж сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод тарих иргэдийг дэмжинэ.

3.1.6. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлнэ.


3.1.7. Голын ай сав, цөлжилт, элсний нүүдэл бүхий газруудыг ойжуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

3.2. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ

3.2.1. Бурхан Буудай, Тагийн мод, Таван элс, Цагаан хаалга зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аймгийн хэмжээний аялал жуулчлалын маршрут гаргаж тэдгээрийн онцлогыг харуулсан богино хэмжээний баримтат кино, шторкуудыг мэргэжлийн өндөр түвшинд хийлгэн сурталчилж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг шинэ шатанд гарган орон нутгийн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.2.2. Аялал жуулчлал эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн цогцолбор, бааз байгуулах төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтарч, онцгойлон дэмжиж ажиллана.

3.2.3. Сумын бахархалт гайхамшигт газар, ан амьтан, уул усны дүрстэй бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж борлуулах талаар санаачлага гарган ажиллаж байгаа иргэд, аж ахуй нэгжийг дэмжиж ажиллана.



3.3. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлнэ.

3.3.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийг шинэчлэн баталгаажуулах, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.

3.3.2. Орон нутаг дахь уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд явуулах хяналтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.3.3. Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч-хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.

3.3.4. Ан амьтдын тооллогыг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл ашиглан хийж, нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлнэ.

3.3.5. Завхан гол, Хяргас нуур, сав газрын зөвлөл, захиргаатай хамтран усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, булаг, шанд, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулна.

3.4. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж


3.4.1. Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл, сургалтыг бүх шатны боловсролын байгууллагатай хамтран хийж, өсвөрийн Байгаль хамгаалагчдыг удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.

3.4.2. Заган ой, модлог ургамлын хамгаалалтын хяналтыг сайжруулан хамгаална.

3.4.3. Булаг шандны эхийг хамгаалан, моджуулж, ургамалжуулах ажлыг малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран хийж, усны ундаргыг нэмэгдүүлнэ.

3.4.4. Усны харуулын тоог нэмэгдүүлж, үүлэнд зориуд нөлөөлөх, хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулна.

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ЗӨВ ЗАСАГЛАЛ



4.1.1.Төрийн албаны ажлын байранд тавигдах шаардлага бүрэн хангаж, нээлттэй шалгаруулалтанд шалгарсан хүнийг төрийн албанд томилдог зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.

4.1.2. Төрийн албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээр намын харъяалалаар хууль бусаар халж, сольж, албан тушаал бууруулж, албан тушаал дэвшүүлж томилдог буруу зуршлыг эцэс болгоно.

4.1.3. Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн Иргэдийн нийтийн хуралд зөвшилцлийн зарчмыг тууштай баримталж, цөөнхийг хүндэтгэж, оновчтой санал, санаачилгыг нь дэмжиж ажиллана.

4.2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ


4.2.1.Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

4.2.2. Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй байлгах бүх нөхцөл шаардлагыг сумын түвшинд жигд хэрэгжүүлж ажиллана.

4.2.3. Хөдөөгийн багуудын ажлын нөхцлийг сайжруулж, багийн дарга, эмч нарыг багт тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.

4.2.4. Иргэд хөдөлмөрчдийн хурал, багийн иргэд нийтийн хурлуудыг сар улирал бүр зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хэвшинэ.

4.3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал



4.3.1. Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангана. Үүний тулд нэг цэгийн үйлчилгээ, шилэн данс, төрийн албаны бусад цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө.

4.3.2. Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй иргэд тогтмол танилцаж байх боломжоор хангана.

4.3.3. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хүнд суртлыг арилган, иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилготой иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийг байгуулж, ажиллуулна.

4.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

4.4.1. Малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болохыг зорино.

4.4.2. Иргэдийн нийгмийн оролцоо идэвхийг бий болгох олон нийтийг хамарсан арга хэмжээ, хууль сурталчилах ажлыг зохион байгуулна.

4.4.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйл хэрэгт олон нийтийн оролцоог дэмжиж, хууль сахиулах байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлнэ.

4.4.4. Хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг тусгай хэрэгслээр хангаж, цагдаагийн хэсгийн мотоциклийг шинэчлэнэ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМЫН МАН-ЫН ХОРОО

